

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо :2019 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр

Тендер шалгаруулалтын нэр: **Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хороо, Гүнтийн давааны орчимд Цагдаа, Мэргэжлийн хяналт, Онцгой байдлын хэлтэс, Замын цагдаагийн хэлтэс зэрэг байгууллагуудын байнгын постын барилгын ажил**

Тендер шалгаруулалтын дугаар: **ЧДХААА А19/01**

**Чингэлтэй дүүргийн Худалдан авах ажиллагааны алба** нь эрх бүхий тендерт оролцогчдоос **“Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хороо, Гүнтийн давааны орчимд Цагдаа, Мэргэжлийн хяналт, Онцгой байдлын хэлтэс, Замын цагдаагийн хэлтэс зэрэг байгууллагуудын байнгын постын барилгын ажил”**–ыг гүйцэтгэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) албан бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэл бүрийг нь 100,000 /нэг зуун мянган/ төгрөгөөр худалдан авч болно. Төлбөрийг Чингэлтэй дүүргийн Худалдан авах ажиллагааны албаны Төрийн сан банкны 100200751009 тоот дансанд тушаана.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

- Борлуулалтын хэмжээ: **Сүүлийн 2 жил /2017, 2018/-ийн дундаж нь 110 000 000 /нэг зуун арван сая/ төгрөгөөс багагүй байна.**
- Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: **50 000 000 /тавин сая/ төгрөгөөс багагүй байна.**
- Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: **Сүүлийн 2 жил /2017, 2018/**
- Сүүлийн 2 жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: **Сүүлийн 2 жил /2017, 2018/-ийн аль нэгэнд ядаж нэг удаа 110 000 000 /нэг зуун арван сая/ төгрөгөөс багагүй үнийн дүнтэй барилга угсралтын ажлын үндсэн гүйцэтгэгчээр ажилласан байна.**
- Шаардлагатай тусгай зөвшөөрөл:
- **2.1.1.** Барилгын засвар, засал чимэглэл, орчны тохижилт
- **2.1.3.** Цутгамал болон угсармал төмөр бетон арагт бүтээцэн болон иж бүрэн цутгамал бүтээцэн, барилгын ажил (1-9 давхар хүртэл) Ган бүтээцэн барилгын ажил (фермийн алгасал нь 18 м, баганын өндөр нь 6 м хүртэл)
- **2.2.1.** Барилгын дотор халаалт, салхивч, ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт
- **2.2.2.** Барилгын дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамж, Холбоо дохиолол,

интернет сүлжээ, гал унтраах болон галын аюулын дохиоллын системийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралт

Эсхүл, Барилга хот байгуулалтын яамнаас олгож байгаа шинэ журмын:

- БА-3.1 Цутгамал болон угсармал төмөр бетон арагт бүтээцэн болон иж бүрэн цутгамал бүтээцэн барилгын угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил.
- БА-6.1 Барилга байгууламжийн дотор ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт.
- БА-6.2 Барилга байгууламжийн дотор халаалт, салхивчийн шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт.
- БА-6.3 Барилга байгууламжийн дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамжийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна шугам сүлжээний угсралт.
- БА-6.4 Барилга байгууламжийн дотор холбоо дохиолол, интернет сүлжээ, гал унтраах болон галын аюулын дохиоллын системийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна шугам сүлжээний угсралт.

Тендерийн хамт **3 000 000 /гурван сая/** төгрөгийн тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг **2019 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 11 цаг 00** минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2019 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 11 цаг 30** минутанд нээнэ.

Гадаадын этгээд: Оролцох эрхгүй.

Дотоодын давуу эрх: Тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, IV хороо, Ж.Самбуугийн гудамж-16,  
Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын байр, 511 тоот өрөө  
Худалдан авах ажиллагааны алба, Утас : 70110769**

## ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

2019.01.04

Чингэлтэй дүүргийн Худалдан авах ажиллагааны алба нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос ЧДХААА А19/03 дугаар бүхий Чингэлтэй дүүргийн 14 дүгээр хороо, 5-н буудлын автобусны буудал орчмын тохижилын ажлыг гүйцэтгэх үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) албан бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэл бүрийг нь 50,000 /тавин мянга/ төгрөгөөр худалдан авч болно. Төлбөрийг Чингэлтэй дүүргийн Худалдан авах ажиллагааны албаны Төрийн сан банкны 100200751009 тоот дансанд тушаана.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Үнийн саналыг 2019 оны 01 дүгээр сарын 15-ны 11 цаг 00 минутаас өмнө Нийслэлийн Нутгийн захиргааны байгууллагуудын II байр буюу Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын байр, 5 дугаар давхар, Худалдан авах ажиллагааны алба, 511 тоот гэх хаягаар ирүүлнэ.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: **Сүүлийн 1 жил буюу 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан ирүүлнэ.**
2. Борлуулалтын хэмжээ: **Сүүлийн 2 жил /2016, 2017/-ийн борлуулалтын орлогын дундаж нь 27 000 000 /хорин долоон сая/ төгрөгөөс багагүй байна.**
3. Ижил төстэй бараа гэрээгээр нийлүүлсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо: **Сүүлийн 2 жил /2016, 2017/ он**
4. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн дүн: **18 000 000 /арван найман сая/ төгрөгөөс багагүй байна.**
5. Тусгай зөвшөөрөл шаардлагатай эсэх: Барилга, хот байгуулалтын яамнаас олгосон:

Хуучнаар **2.1.1 Барилгын засвар, засал чимэглэл, орчны тохижилт**

Шинээр **БА-8.1 барилга байгууламжийн засвар, засал чимэглэл, интерьер, орчны тохижилтын ажил**

Эсхүл, Зам тээврийн яамнаас олгодог **2.8.1 Хатуу хучилттай автозам барих**

Эсхүл, Зам тээврийн сайдын 2013 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 152 дугаар тушаалаар батлагдсан “Авто зам, замын байгууламжийг барих, засварлах тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох журам”-ын **3.7.1.1 ЗБ-1 Хатуу хучилттай зам барих заалтанд хамаарах төрлийн тусгай зөвшөөрөл**

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан 2019 оны 01 дүгээр сарын 15-ны 11 цаг 20 минутад нээнэ.

Гадаадын этгээд: Оролцох эрхгүй

Дотоодын давуу эрх: Тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

*Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, IV хороо Ж.Самбуугийн гудамж-16,  
Нийслэлийн Нутгийн захиргааны байгууллагуудын II байр, Чингэлтэй  
дүүргийн Засаг даргын Тамгын газрын байр Худалдан авах  
ажиллагааны алба 5 дугаар давхар, 511 тоот Утас : 70110769*